



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/152

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.1.7, 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага" сэдэвт сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтын дагуу төсвийн зохих зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, үр дүнг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг /Ч.Баттулга/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



420568

Ерөнхий захирлын 2017 оны 08 дугаар
сарын 29-ны өдрийн А/Б/С дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

“ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА” СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь ажлын ачаалал, сэтгэл зүйн дарамт, стрессээс улбаатай ёс зүй, хайнга байдлын алдаа зөрчилд цөөнгүй орж, хариуцлага алдах тохиолдол жил бүр гарч байна. энэ нь ёс зүйн шийтгэл, улмаар эрүүгийн хариуцлага хүлээн мэргэжлээрээ ажиллах боломжгүй болох зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байна.

Алдаа зөрчил гарган, гэм буруутай үйлдэл хийсэн тохиолдолд шийтгэл оногдуулах хууль эрх зүйн орчин шинэчлэгдсэн. ЭМХТ-өөс Монгол Улсын Төрийн албаны тухай хууль болон Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр д онд хийсэн “Эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл зүйн ачаалал” судалгаанд ёс зүйгүй байдал нь сэтгэл зүйн хүнд дарамт болдог тухай судалсан байна. иймд алдаа зөрчил гаргахад нөлөөлж буй ёс зүй, харилцаа хандлагын мэдлэгийг сэргээх, асуудалд суурилсан шийдвэр гаргах үр чадварт суралцуулах нь сургалтын гол үндэслэл болж байна. Мөн төвийн болон ЭМЯ-ны харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийн удирдлагын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

Хоёр. Зорилго

Эрүүл мэндийн хөгжлийн төв болон ЭМЯ-ны харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчдад Ёс зүй, харилцааны үр чадварын мэдлэг хандлагыг сэргээж, асуудал тодорхойлох, шийдвэр гаргах, гүйцэтгэлийг төлөвлөх, үнэлэх үр чадварт суралцуулах

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

2017 оны 9 сарын 04

Дөрөв. Зохион байгуулагч

ЭМХТ-ийн ХШҮДАБ

Тав. Хамрах хүрээ

ЭМЯ-ны харьяа байгууллагуудын болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажилтан, албан хаагчид

Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

ЭМЯ-ны харьяа байгууллагуудын болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажилтан, албан хаагчид ёс зүйн тулгамдсан асуудлыг зөв тодорхойлон, зөв шийдвэр гаргах, ёс зүйн болон гүйцэтгэлийн удирдлагын үр чадвар эзэмшинэ.

**" ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА"
СЭДЭВТ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

2017 оны 09 дүгээр сарын 04,05-ны 09.00 цагаас ЭМХТ-ийн Хурлын танхимд болно.

Хугацаа	Сэдэв	Илтгэгч
09-р сарын 04 /Даваа гараг/		
10.00-10.10	Нээлт	Б.Нарантуяа, ЭМХТ-ийн Ерөнхий захирал
10.10-10.40	Зөрчлийн тухай хуулийн танилцуулга	Хуулийн зөвлөх М.Цэнгүүн
10.40-11.00	Асуулт хариулт	
11.00-11.15	Цайны завсарлага	
11.15-11.45	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, алдаа зөрчил	ЧМИА-ны дарга Н.Нарангэрэл
11.45-12.00	Асуулт хариулт	
13.30-14.30	Үдийн хоол	
14.30-15.00	Гүйцэтгэлийн төлөвлөлт	ХШУДАБ-ийн дарга Ч.Баттулга
15.00-15.15	Асуулт хариулт	
15.15-15.30	Цайны завсарлага	
15.30-16.00	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дотоод аудитын мэргэжилтэн Б.Батнаран
16.00-16.15	Асуулт хариулт	
16.15-17.00	Гүйцэтгэлийн үнэлгээ	Дотоод аудитын мэргэжилтэн Б.Батнаран
17.00-17.15	Асуулт хариулт	
09-р сарын 05 /Мягмар гараг/		
10.10-10.40	Шинэчлэгдэн батлагдсан Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний тухай журмын танилцуулга	Хуулийн зөвлөх М.Цэнгүүн
10.40-11.00	Асуулт хариулт	
11.00-11.15	Цайны завсарлага	
11.15-11.45	Үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага - Үйлчлүүлэгчийн хүлээлт ба үйлчлэх сэтгэл	ЧМИА-ны дарга Н.Нарангэрэл

	- Хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах ур чадвар	
11.45-12.00	Асуулт хариулт	
13.30-14.30	Үдийн хоол	
14.30-15.00	Стресс, ёс зүй, харилцаа хандлага нь алдаа зөрчил гаргахад нөлөөлөх нь	Ц.Амаржаргал
15.00-15.15	Асуулт хариулт	
15.15-15.30	Цайны завсарлага	
15.30-16.00	Танилцуулга: Эмч эмнэлгийн мэргэжилтний сэтгэл зүйн ачааллын судалгааны үр дүн	Л.Ширнэн
16.00-16.15	Асуулт хариулт	
16.15-17.00	Хэлэлцүүлэг: Үйлчилгээ авахад үйлчилгээ үзүүлэгчийн ёс зүй, харилцаанд ямар хандлага таалагдсан, таалагдаагүй вэ?	Дотоод аудитын мэргэжилтэн Б.Батнаран

Ерөнхий захирлын 2017 оны 08 дугаар
сарын 29 -ны өдрийн 4/2 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**“ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА”
СЭДЭВТ СУРГАЛТЫН ТӨСӨВ**

Д/д	Зардлын нэр	Нэгж тооцоо	Төсөвлөсөн /төг/
1	Бичиг хэрэг	(80*1500)*2өдөр	240000
2	Олшруулах, хэвлэх зардал	(80*100*20хуу)*2өдөр	320000
3	Цайны зардал	(80*2000*2)*2өдөр	320000
4	Хоол	(80*8000)*2өдөр	1280000
5	Багшийн ажлын хөлс /Магистр/	(3*10000*8цаг)*2өдөр	240000
6	Анонс		100000
7	Бусад		284482
	Нийт дүн		2784482

Хянасан:

Д.Гантуяа

Боловсруулсан:

Б.Батнаран